

БАТЛАВ.
Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Хүрээлэн буй орчин байгалийн
нөөцийн удирдлагын газрын дарга:
/А.Энхбат/



“Алтайн үндэс констракшн” ХХК-ийн 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

: 2550792/

Хянасан:
БОАЖЯ, хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн
удирдлагын газрын мэргэжилтэн

/П.Шинэцэцэг/

Төлөвлөгөө боловсруулсан:
“Алтайн үндэс констракшн” ХХК
Байгаль орчны менежер:

/Д.Мөнх-Өлзий/

2022 он

ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	8
ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	11
ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	13
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ....	14
ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	19
НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	20
ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	22
АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	23
11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	24
12. ДҮГНЭЛТ	25

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр ХХААХҮЯамны захиалгаар хэрэгжиж буй “Хүнсний ногооны үйлдвэрлэл бах усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хүрээнд услалтын системийн барилга байгууламжийг шинэчлэх сэргээн засварлах зорилгоор Говь-Алтай аймгийн Жаргалан сумын нутагт хэрэгжиж байгаа “Цахир дэд төсөл”-ийн барилгын ажил Гүйцэтгэгчээр “Алтайн үндэс констракшн” ХХК шалгарч, ХХААХҮЯ-тай 2021 оны 9 сарын 20-ны өдрийн СW-5-1 тоот хамтран ажиллах гэрээ байгуулсан.

“Цахир услалтын систем” төслийн нийт талбай 200.6 га, барилга угсралтын ажил 2022 оны 2 улирлаас эхэлж 2 жилийн хугацаанд явагдана. Энэ талбай нь Говь-Алтай аймгийн Жаргалан сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт “Цахирын тал” нэртэй газар байрлах ба Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Засаг даргын тамгын газрын мэдэлд байна.

“Цахир” услалтын системийн засвар шинэчлэлийн ажлын зургийг “Мөнгөн минж” ХХК, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг “Грийн Натур Ланд” ХХК, “Нью Грийн Ворлд” ХХК, “Экос” ХХК-иуд хамтран гүйцэтгэж, БОАЖЯ-аар баталгаажуулсан.

ТӨСЛИЙН БАЙРШИЛ. “Цахир” услалтын системийн төсөл хэрэгжих талбай нь Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Завхангол (3-р баг) багийн нутаг дэвсгэрт байрлах бөгөөд Улаанбаатар хотоос 1120 км, Жаргалан сумын төвөөс зүүн зүгт 15 км-т байрлана Жаргалан сум нь баруун, баруун хойд талаараа Говь-Алтай аймгийн Баян-Уул сумтай, зүүн хойд талаараа Завхан аймгийн Улиастай, Цагаанхайрхан сумдтай, зүүн талаараа Завхан аймгийн Цагаанчулуут сумтай, зүүн урд талаараа Говь-Алтай аймгийн Тайшир сумтай тус тус хиллэдэг.

Говь-Алтай аймгийн Жаргалант сумын Цахирын услалтын системийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө



Зураг 1. "Цахир" услалтын системийн төсөл хэрэгжих талбайн байршил

1.1 2023 онд явуулах барилга, угсралтын ажлын төлөвлөгөөний товч

“Цахир” услалтын системийн төсөл хэрэгжсэнээр: Аван камер, Насос станц, Гол хоолой, Бороожуулах машин, Хоослох худаг зэрэг үндсэн болон туслах барилга байгууламж, тоног төхөөрөмжийг суурилуулахаар ажлын зурагт тусгасан байна.

Ус татах байгууламж: Завхан голоос аван камераар дамжуулан насосоор ус авна. Насос станцын найдвартай ажиллагааг нь бодож 2 насос төлөвлөсөн болно. Тухайн насос станц нь барилга дотор байрлана. Насос станцын 1 нь ажиллах бөгөөд эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд нөөц насос ажиллуулахаар төлөвлөсөн болно. Насос станцыг ажиллуулж дууссаны дараа доторх усыг шавхаж, тосолж, нийлэг уутаар сайтар битүүмжилж хадгална. Насосын суурийг зургийн дагуу хийж барилга дотор ус тогтохгүй байх нөхцөлийг хангаж шал ус зайлуулах тарифтай байна. Насосыг суурьтай сайтар бэхэлж, савлалт, сул доргилтоос сэргийлнэ. Цахилгааны шит дотор байж болох ба тусдаа хайрцагтай байна. Тухайн насосоор бороожуулах машин луу ус шахна.

Насос станц: Усан сангаас усыг насосаар далд сүлжээ рүү шахаж, далд сүлжээгээр /хоолойгоор/ дамжуулан тойргоор усалдаг бороожуулагчдыг усаар хангана. Насос станцад 2 ширхэг Grundfos NB 150-315.2/314 маркийн насос суурилагдана.

Ус дамжуулах далд сүлжээ: Бороожуулагчийн хэвийн ажиллагааг хангах зорилгоор 250-400 мм хоолойг гидравлик аргаар тооцсон болно. Хоолойн эхлэл өндөрлөг хэсэгт вантуз хийхээр төлөвлөсөн байна. Тухайн хоолойнд тохирсон вантузыг тооцож үзэхэд 50 см урттай Ф20 мм хоолойд угсарна. Хоолойн даралт даах чадварыг тооцож HDPE SDR21 маркийн 0.8 Мра сонгосон байна. Гол хоолойн нийт урт 6181м, ба үүнээс: хоолой HDPE Ду=400мм-4142м, хоолой HDPE Ду=355мм-663м, хоолой HDPE Ду=315мм -538м, хоолой HDPE Ду=250мм-475м тус тус урттай байна. Төгсгөлд гол хоолойг хоослох зорилгоор Ду=50мм ийн HDPE хоолой 363м-ийг хоослох худгийн хамт төлөвлөсөн болно. Тухайн хоолойн төгсгөлд усны энерги унтраах хийц төлөвлөсөн болно.

Юүлэх худаг: Гол болон юүлэх хоолойн огтолгоод худаг төлөвлөв. Тухайн 50мм голтой хоолойд хаалт хийж өгөх ба усалгаа дууссан үед тухайн хаалтыг нээж хоолойг хоослох шаардлагатай. Услалтын системийн далд сүлжээг өвлийн улиралд аюулгүй хадгалахын тулд усыг юүлэх худгаар тус тус зайлуулна.

Усалгааны бороожуулагч машин: Услалтын системийн талбай 10 хэсгээс бүрдэх ба I, II талбайд DYP-6,3 бороожуулагч, III, IV, IX хэсгүүдэд DYP-13,31, V, VI, X хэсгүүдэд DYP- 22,5, VII, VIII хэсгүүдэд DYP-34.2

бороожуулагчийг байрлуулна.

Цахилгаан хангамж: Сум нь төвийн эрчим хүчний системд холбогдсон. Сумын төв дээр 2008 онд баригдсан 35/15квт-ын дэд станцтай. Дэргэдүүр өнгөрөх 35кВт шугамаас 35/04-600 трансформатораар цахилгаан авч, 6500м цахилгааны шугам, шахуурга станц, бороожуулах машиныг тус тус ажиллуулахад шаардагдана.

Торон хашаа: Шинээр татах хашаа нь 5.0 м-ийн алгасалтай модон шонтой 10.2 км төмөр утсан торон хашааг талбайн эргэн тойронд татах ба 2 хаалгатай байна.

Газар шорооны ажил: Хуванцар хоолой байрлах шуудууг өнгөн хөрсийг хуулсны дараа экскаватороор ухаж шуудууны ёроолыг нивелирдэн 20 м тутамд төслийн тэмдэгтэд модон гадас зоож түүнтэйгээ уялдуулан гараар тэгшилгээ хийж янданг оруулж тавихад бэлтгэнэ. Газар шорооны ажлыг механизмаар гүйцэтгэхэд хэтэрхий гүнзгий ухаж болзошгүй бөгөөд тэр нь дахин шороо хийж дээр нь барилга байгууламж, хуванцар хоолой зэргийг байрлуулахад сул шороо суудаг муу нөлөөтэй учраас хэт ухуулахгүйн тулд төслийн тэмдэгтийн зохих түвшнээс 10 см орчим үе орхин дутуу ухуулж дараа нь гараар гүйцээж ухуулж байх хэрэгтэй.

Хуванцар хоолой болон бусад арматуруудыг шуудуунд төслийн тэмдэгтэд байрлуулсны дараа гараар булж, 2 талаар нь хөдөлгөөнгүй болгож хоолойн залгаасын бат бэхийг усаар буюу хийгээр шахаж шалгана. Хоолойн холболтыг бүрэн шалгасны дараа яндангийн нуруун дээр 20 см хүртэл зузаан шороог шуудууны налууг дагуулж бульдозерээр түрж гараар тарааж овоолно. Үүнээс дээших хэсгийг бульдозерээр түрж тэгшилнэ. Бульдозерээр үндсэн шороог тэгшилсний дараа ургамлын өнгөн хөрсийг тарааж өгнө. Түрж тэгшилсэн шороо нь нягтруулга муутай тул суун хотойдог учир шуудууны дээр гөвгөр болгон үлдээх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл өнгөн хэсэг нь овгор байх хэрэгтэй цаг хугацаанд хөрс чигжигдэхэд хотойхгүй, мөн өнгөн хөрсөө тэгшлэхгүй юм.

1. **Бетоны ажил:** Уг системд бетоны ажил нилээд хэмжээгээр хийгдэнэ. Аван камераар ус авах хэсэг, вантузтай худаг, Юүлэх худаг зэрэг барилгуудад цул ба цул төмөр бетоны ажлууд хийгдэнэ. Бетон зуурмагийг бэлтгэхдээ БНМАУ-ын УААЯ-ны сайдын 1977 оны 36-р тушаалын хавсралтад заасан орцын нормыг баримтлах ёстой.
2. Зохих марканд тохируулсан нормын дагуу зуурсан зуурмагийг хамгийн явцуу өнцөг булангаас эхлэн үелүүлэн хийж цутгаж нягтруулна. Цутгасан

Говь-Алтай аймгийн Жаргалант сумын Цахирын услалтын системийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

бетон хана барилгын хойш 3-аас доошгүй хоногийн дараа цутгасан эдлэлээ доргиож эвдэхгүй салгаж авах хэрэгтэй. Бетон эдлэлийг бэхжиж хатсаны дараа булагдах хэсгийг битумээр будаж шороогоор буцааж булах ажил хийнэ.

3. **Хуванцар хоолой хоолойг угсрах ажил:** Услах системийн гол, хувиарлах, усалгааны хоолойнуудад Ду=450, 300, 250, 50 мм–ийн голчтой 6.2 км урт хуванцар хоолой угсрана.

1.2 2023 онд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө

	Услалтын системийн барилга, угсралтын ажлын төлөвлөгөө	Үйл явц	Хугацаа	Болзошгүй сөрөг нөлөөлөл
	Услалтын тоног төхөөрөмжүүдийг тээвэрлэх, барилга угсралтын ажлын үе			
1	Шугам хоолойн наалт	тоног төхөрөөмжийг тээвэрлэх	4...8 сарын хооронд	материалын хог хаягдал
2	Тэгшлэлт, шугам хоолойн булалт	Газар шорооны ажил	4...6 сарууд	хөрс, ургамлан бүрхэвч
	Агуулахын барилга		5 сар	
3	Бороожуулагч машин угсрах		5-6 сар	
	Цахилгааны ажил		6-7 сар	
	Аванкамер, насосны зогсоол		7 сар	
	Ус өгөх гидрантын суурь, тоноглол угсрах ажил		8 сар	
	Юүлэх худаг			
1	Гараар газрыг ухаж, бульдозерээр хөрс түрэх, тэгшлэх, булах	газар шорооны ажил	7 сар	хөрс, ургамал
2	Захиалсан юүлэх худгийн тоног төхөөрөмж авчрах, угсрах	тээвэрлэлт	7 сар	агаар орчин
3	Элс, хайрга авчрах, дэвсэх	тээвэрлэлт		агаар орчин
4	Төмөр шат угсрах, худгийн ул тулгуур цутгах		8 сар	
5	Бульдозероор хөрс түрж хүнхээл ба шуудууг булах	Газар шорооны ажил	8сар	Хөрс, ургамал
	Ойн зурвас байгуулах			
1	Захиалсан суулгацуудыг авчрах,	тээвэрлэлт		агаар орчин
2	Тарьц суулгах талбайг бэлтгэх, суулгах, арчлах	Газар шорооны ажил, усалгаа хийх	5 сар	Хөрс, ургамал, ус
	Хяналтын цооног байгуулах			

1	Тариалангийн талбайн хоёр цэгт (Цооног 1- 46°53'38.28"N, 96°10'45.97"E, Цооног 2- 46°52'43.66"N, 96°13'23.83"E) 20 метрийн гүнтэй хоёр ширхэг мониторингийн цооног гаргах	газар шорооны ажил, хяналтын цооног	6 сар	хөрс, ургамлан бүрхэвч, ус орчин
---	---	-------------------------------------	-------	----------------------------------

ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Газрын гадарга, физик газарзүйн онцлог. “Цахир” услалтын системийн төсөл хэрэгжих талбай нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Говийн их муж, Алтайн ар говийн мужын Их нууруудын хотгор тойрогт хамаарагдах ба Их нууруудын хотгор нь Төв Азийн уул нуруудын хоорондох гүнзгий сав газарт дэлхийн бөмбөрцөгийн умард өргөргийн 46°-51°, зүүн уртрагийн 92°-96° хооронд Алтай Хангайн уулт тогтолцоог тусгаарлан уртрагын дагуу сунаж тогтсон тектоник гаралтай хотгор юм. Иймд их нууруудын хотгор нь газарзүйн байрлал, гадаргын төрх, хэлбэр, хэмжээ, ландшафтын хослолоороо бусад хотгороос гойд ялгарна. Геоморфологийн хувьд Их нууруудын хотгорт элэгдэл хуримтлалын ба хуримтлалын хэв шинжит хотгор гүдгэр зонхилно. Иймд эдгээр хэв шинжид хамрагдах цав толгодууд, делюви- пролювийн хурдаст хэвгий тал, нуур, голын хурдаст тэгш тал, элсэн хуримтлал, хужир марз бүхий хотгорууд өргөн тархалттай.

Монгол улс хамгийн нам доор газраа далайн түвшнээс дээш 560 метр өндөрт, хамгийн өндөрлөг газраа далайн түвшнээс дээш 4374 метр өндөрт өргөгдсөн харьцангуй өндөрлөг газар оршдог орон юм. Төслийн талбай нь Говь -Алтай аймгийн Жаргалан сумын нутагт Завхан голын хөндийд байршилтай ба далайн түвшнээс дээш 1497-1508 метрийн өндөрт байрлана.

Төслийн талбай нь баруун талаасаа эхлээд баруун хойд, хойд, зүүн, зүүн урд, урд талаараа 5- 10 км-ийн зайд Хүрэн толгой (1586 м), Их цахир уул (1621 м), Бага цахир толгой (1571 м), Хацавч толгой (1458 м), Голын улаан толгой (1506 м), Их бүрхээр (1643 м), Туулай толгой (1603 м), Доод хар хошуу (1581 м), Улаан толгой (1666 м) зэрэг нам уулс, цав толгодын хүрээлэгдсэн байна.

Ургамлан бүрхэвч. Төслийн талбай нь Монгол орны байгалын бүс, бүслүүрийн хувьд “Цөлөрхөг хээрийн бүс”-д хамрагдаж байна. Монгол оронд хойноосоо урагшлахад уур амьсгал хуурайшиж, ургамалжилтын бүсүүд илэрч хуурай хээрийн, цөлжүү хээрийн, цөлийн хээрийн бүсүүд ялгарна. Монгол орны хээрийг нийт 54 овог, 227 төрөлд хамаарах элбэг тархацтай 614

зүйлийн дээд гуурст ургамал бүрдүүлнэ. Цөлөрхөг хээрт Өдлөг хялгана-боролзойт хээр, Өдлөг хялгана-таанат цөл, Өдлөг хялгана-бударганат, Харгана-өдлөг хялганат, Тэсэг-өдлөг хялганат, Хотир-өдлөг хялганат, Шаваг-өдлөг хялганат, Бор бударганат, Бор бударгана-хойрогт, Баглуурт болон сөөгт цөлөрхөг хээр их тохиолдоно /Өлзийхутаг, 1989/.

Геологийн тогтоц. Говь-Алтай аймгийн дэвсгэр нутагт геологийн тогтоц нь архей- протерозойн хувирмал чулуулгаас палезой, мезозойн эх газрын тунамал вулканоген чулуулаг болон кайнозойн хурдас хуримтлалаас тогтоно. “Цахир” услалтын системийн төсөл хэрэгжих талбайд бүхэлд нь дээд плиоцений хурдас чулуулаг тархсан байна. Энэхүү хурдас чулуулаг нь бор, хүрэн ба улаавтар наанги, зануу, наагжин, хайргажин, лаг шавар, шавар, чулуулгийн хэлтэрхий зэргээс бүрэлдэх бөгөөд зузаан нь 20-40 м-ээр хэмжигдэнэ. Төслийн талбайн баруун хойд, зүүн хойд, зүүн урд хэсгүүдээр дөрөвдөгчийн (Q4) үеийн хайрга, лакустрин, лазустрин-алюв, алювийн хурдас чулуулаг тархсан бол зүүн урд хэсгээр дээд болон доод неогений үеийн (N1, N2) ногоовтор, ногоон карбонат-шавар, шавар, хайрга, базальт тархжээ. Төслийн талбайн баруун болон зүүн хойд, урд талаар Дээд рифейн (R3, xR3) габбро, шүлтлэг гранит, лейкогранит, базальт, дунит, приксонит-габбро, Вендийн (V) үеийн базальт, андезитын лаав, хувирсан ногоон занар, доломит, кальци-шаварлаг занар зэрэг хурдас чулуулаг тархсан байна.

Геоморфологи. “Цахир” услалтын системийн төсөл хэрэгжих талбай нь геоморфологийн мужлалаар Нууруудын хөндий, хотгорын мужийн Их нууруудын хотгорын дэд мужид хамаарна. Нууруудын хөндий, хотгорын мужид ихэвчлэн пролюви, нуур пролювийн, гол-пролювийн хурдаст талын гадарга зонхилох ба Хяргас, Хар, Дөргөн, Ойгон нуур орчмоор нуурын хурдаст тал, бусад хэсгээр салхины үйлдлээр үүссэн тал зонхилно. “Цахир” услалтын системийн төсөл хэрэгжих талбайд “Тэгширмэл газар, уулс хоорондын ба уулан дундах хотгор, голын хөндий дэх хурмал хурдаст хотос гадарга (N²-Q¹, Q)” бүхий “аллювийн тэгш тал” тархсан байна.

Цэвдэг, түүний тархалт. “Цахир” услалтын системийн төсөл хэрэгжих талбай нь 1970-аад оны цэвдгийн тархалтын судалгаагаар “Олон жилийн цэвдэг чулуулаг тохиолдлын тархалттай бүслүүр” –т хамаарч байсан бол 2016 оны судалгаагаар төслийн талбайн тохиолдлын тархалттай цэвдэг устаж “Улирлын хөлдөлтийн бүс” ангилалд хамаарах болсон байна. Өөрөөр хэлбэл сүүлийн жилүүдэд эрчимтэй явагдаж буй уур амьсгалтын өөрчлөлтийн улмаас цэвдгийн тархалт ихээхэн өөрчлөгдөж, улмаар гадаргын усыг хөрсөнд шингэж нэвчихээс сэргийлдэг тохиолдлын тархалттай цэвдэг устаж

тархалт нь хумигдах болсон байна.

Амьтны аймаг. Төсөл хэрэгжих талбай нь байгалийн бүс бүслүүрийн хувьд цөлөрхөг хээрийн бүсэд хамаарах ба Монгол орны зоогеографийн мужлалтаар Говь-Алтайн тойрогт хамаарна. Тиймээс говь, цөлийн амьтад зонхилон тархана. Талбайн орчимд сээр нуруугүйтэн амьтдаас үет хөлтний хүрээнд хамаарах шавьж *Шүрэн цох-Coccinella septempunctata*, *Голуо-Deragoniidae onos* болон аалз хэлбэртний ангийн төлөөлөгч түгээмэл тархана. Мөн 8 зүйл хоёр нутагтан, мөлхөгч тархсан бөгөөд үүнээс ховордож болзошгүй 1, бусад зүйлүүд нь бүс нутгийн болон олон улсын хамгааллын статуст анхааралд өртөхөөргүй, үнэлгээ хийгдээгүй гэсэн ангилалд хамаарч байна.

Нийгэм эдийн засаг. “Цахир” услалтын системийн төсөл хэрэгжих талбай нь Говь-Алтай аймгийн Жаргалант сумын нутагт байрлана. Говь-Алтай аймгийн Жаргалант сум нь хуучнаар Засагт хан аймгийн Үйзэн гүний хошуу бөгөөд 1924 оны 06 дугаар 05–ны өдрийн Хантайшир-Уулын аймгийн Мөнх–Өлзий дэлгэр Уулын хошууны иргэдийн анхдугаар хурлаар байгуулагджээ. Энэ хурлаар тус хошуунд Батбуянт-Уулын сум, Жаргалант-Уулын сум гэсэн 2 суманд 249 өрх, 10 гэр, 6 баг харгалзуулан зохион байгуулжээ. Хожим нь дээрх 2 сум нэгдэн 1924 онд Жаргалант сумыг байгуулсан түүхтэй. Сумын газар нутгийн баруун захаас зүүн захын цэг хүртэл шулуун шугамаар 85 км, хойноос өмнөд цэг хүртэл 83 км байдаг. Улаанбаатар хотоос 1100 км, аймгийн төвөөс 110 км зайд байрладаг. Тус сум нь баруун, баруун хойд талаараа Говь-Алтай аймгийн Баян-Уул сумтай, зүүн хойд талаараа Завхан аймгийн Улиастай, Цагаанхайрхан сумдтай, зүүн талаараа Завхан аймгийн Цагаанчулуут сумтай, зүүн урд талаараа Говь-Алтай аймгийн Тайшир сумтай тус тус хиллэдэг. Засаг захиргааны нэгжийн хувьд Бүрэн (1-р баг), Тээл (2-р баг), Завхан гол (3-р баг) гэсэн 3 багтай, 3683 км нутаг дэвсгэртэй. Монгол орны нийт газар нутгийг газар ашиглалт, газрын нэгдмэл сангийн ангилалаар “усан сан бүхий газар”, “ойн сан бүхий газар”, “тусгай хэрэгцээний газар”, хөдөө аж ахуйн газар”, “хот тосгон бусад суурин газар”, “бусад газар” гэж ангилж бөгөөд “Цахир” услалтын системийн төсөл хэрэгжих талбай нь энэ ангилалаар “ойн сан бүхий газар”-ын ангилалд хамаарч байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар Жаргалант суманд 499 өрхийн нийт 1801 хүн оршин сууж байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад 1.4 хувиар буурсан байна. Үүнээс Бүрэн багт 213 өрхийн 784 хүн, Тээл багт 141 өрхийн 534 хүн, Завхан гол багт 140 өрхийн 483 хүн оршин сууж байна. Нийт хүн амын 19 орчим хувь нь сумын төвд, үлдсэн хөдөө амьдардаг. Сумын иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл 0-14 насны иргэд 509 буюу нийт хүн амын 28.2 хувийг, 15-19 насны иргэд 157, 20-29 насны иргэд 303, 30-39

насны иргэд 239, 40-49 насны иргэд 261, 50-59 насны иргэд 200, 60-с дээш насны иргэд 132 байна. Нийт иргэдийн 44.6 хувийг хөдөлмөрийн насны залуучууд эзэлж байна. Хөдөлмөр эрхлэлтийн байдлыг авч үзвэл 2019 онд ажилгүй 12 хүн бүртгэгдсэн ба өмнөх оноос 9.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Төрийн өмчит сургуулийн өмнөх боловсролын байгууллага нэг байх ба 3 үндсэн багштай. Жилд нийт 88 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан байна.

Жаргалан сумын нийт малын тоо толгой 2021 оны жилийн эцсийн байдлаар 177700-д хүрч өмнөх оноос 5,5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Нийт малын 33.5 хувийг хонь, 63,8 хувийг ямаа, 3.37 хувийг адуу, 0.5 хувийг тэмээ, 1.1 хувийг үхэр, мөн 1.1 хувийг адуу эзэлж байна. Нийт Нийт малчдын 57 хувь нь эрэгтэй, 43 хувь нь эмэгтэй хүн байна. 2019 онд 4га талбайд төмс, 0.6га талбайд хүнсний ногоо, 10га талбайд тэжээлийн ургамал тариалсан байна. Харин үр тариа тариалаагүй байна. Жаргалан сумын ургац хураалтын байдлыг авч үзвэл 2019 онд 5.5тн төмс хурааж өмнөх оноос 2.2 дахин их, 2.8тн хүнсний ногоо хурааж өмнөх оноос 1.7 дахин их, 20тн тэжээлийн ургамал хураасан үзүүлэлттэй байна.

ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын нутагт хэрэгжих “Цахир” услалтын системийн барилга угсралтын үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчин, нийгэм эдийн засаг болон хүний эрүүл мэндэд үзүүлэх гол ба болзошгүй нөлөөллийн дүн шинжилгээг үндэслэн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээний зөвлөмжүүдийг боловсрууллаа.

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Услалтын системийн усалгааны гол сувгийг засварлах, насос станцын барилга байгууламжийг барих, усалгааны тоног төхөөрөмжүүдийг суурилуулах зэрэг барилга, газар шорооны ажлын үед материал тээвэрлэлт болон бусад ажилбаруудаас үүдэлтэй орчны агаарт үүсгэх гол сөрөг нөлөөлөл нь тоосжилт байх юм. Тоосжилт нь барилгын материалуудыг шороон замаар тээвэрлэн төслийн талбайд авчрах, элс хайрга, цемент зэрэг тоос үүсгэх материалыг талбайд түр хадгалах, техник хэрэгсэл ашиглах зэрэг олон талт үйл ажиллагааны үед үүснэ.

1. Усалгаа. Замыг услах нь тоос дарах хамгийн энгийн арга юм. Энэхүү аргыг хэрэглэхэд замыг урьдчилан бэлтгэх шаардлагагүй бөгөөд ус шүршигч

машинаар замын гадаргууг усалж норгоно.

2. Стандартын шаардлага хангасан барилгын материал ашиглах. Барилга газар шорооны ажлын үед “Барилга байгууламжийн ажилд хэрэглэх элс, хайрга, дайргын стандарт MNS-392-98”-ын шаардлага хангасан буюу сайтар угааж шигшиж ангилсан элс, хайрга, дайрга ашиглах нь зүйтэй. Угааж шигшсэн элс, хайрганаас үүсэх тоосжилт харьцангуй бага байдаг байна.

3. Тээврийн хэрэгслийн хурдны хяналт. Нягтруулга багатай, сул шороо ихтэй, шороон замаар барилгын материалын тээвэрлэлт хийх болон бусад зорилгоор зорчихдоо хурдны хязгаар тогтоох нь тоосжилтыг хянах үр дүнтэй аргуудын нэг юм. Энэ арга нь ажлын бүтээмжинд сөргөөр нөлөөлдөг боловч хурдыг 40 км/цаг-с 16 км/цаг болгож бууруулахад замаас үүсэх 10 микроноос бага ширхэгтэй тоосонцрын хэмжээ 58 %-иар, хурдыг 40 км/цаг- с 24 км/цаг болгоход 42 %-иар тус тус буурах боломжтойг судалгаагаар тогтоосон байдаг. Өөр судалгааны дүнд шороон замаар зорчих тээврийн хэрэгслийн хурдыг 40 км/цаг-р хязгаарлахад тоосжилтыг бууруулах үр ашиг нь 44% орчим байна гэж үзжээ [БОННУ].

Салхины хаалт. Салхины хаалтууд нь ихэвчлэн задгай талбайн салхины элэгдлээс хамгаалах зорилгоор хийгддэг ба талбайг тойруулан мод, бут сөөг, зүлэг тарьдаг. Тарималжуулсан ургамал (зүлэг, мод, бут сөөг) ургасны дараа талбайг салхины элэгдлээс хамгаалахаас гадна үр нь талбайн хэмжээнд тархаж ургамалжих нөхцөлийн бүрдүүлдэг [Woodruff et al. 1977]. Ургамлын тоос барих үр ашиг нь тэдгээрийн төрөл зүйл, хоорондын зайнаас хамаарч 10 микроноос бага диаметртэй тоосонцрын хувьд 35-80% байдаг.

Энэхүү услалтын системийн зураг төсөлд тариалангийн талбайг тойруулан 10175 метр урттай 3 эгнээ ойн зурвас байгуулахаар төлөвлөсөн нь урт хугацаанд тоосжилтыг бууруулах, хөрс хамгаалахад чухал ач холбогдол бүхий арга хэмжээ тул төслийн төлөвлөлтийн дагуу ойн зурвасыг байгуулах, ойн зурвасын усалгаа, арчилгааг тогтмол хийж байх шаардлагатай.

Услалтын системийн барилга газар шорооны ажлын үед ашиглах элс, хайрга, цемент зэрэг материалуудын овоолгоос салхины үйлчиллээр тоос босох тул салхины хурд ихтэй үед полиэтилен болон даавуун хучлагаар хучих, барилгын материалын овоолгыг аль болох бага талбайд үүсгэх, газрын гадаргаар тархахаас сэргийлж хаалт, хашилт хийх, салхинд хийсч тоос үүсгэхгүйц материал тээвэрлэхдээ тээврийн хэрэгслийн ачааны хэсгийг битүүмжлэн хучих арга хэмжээ авах шаардлагатай.

Хийн төлөвт бохирдуулагчийг бууруулах арга хэмжээ. Услалтын системийн барилга болон барилга байгууламжийг холбох угсралтын үед газар шорооны

ажлууд ихээр хийгдэх тул бензин, дизель түлшээр ажилладаг машин механизм, техник тоног төхөөрөмжүүдийг ашиглах бөгөөд тэдгээрийн дутуу шаталтат хөдөлгүүрээс хийн төлөвт бохирдуулагч ялгарч орчны агаарыг бохирдуулдаг. Дизель хөдөлгүүрийн хаягдал утаанд янз бүрийн агаар бохирдуулагчид агуулагдах ба ялангуяа азотын ислүүд, хөө тортог (тоосонцор)-н ялгаруулалтын хэмжээ бусад бохирдуулагчидтай харьцуулахад нэлээд их байдаг. Дизель болон бензин хөдөлгүүрийн хаягдал утааг бууруулах зорилгоор сайн чанарын түлш ашигласнаар хөдөлгүүр сайжирч, хаягдал утааны ялгарал буурдаг.

ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Тухайн жилийн Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нарийвчилсан үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой.

Энэхүү төлөвлөгөөгөөр алт олборлолтын үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний хуваарийг тогтоож өгөв.

Тухайн жилийн байгаль хамгаалах төлөвлөгөө нь орчны хяналт шинжилгээний хөтөлбөртэй нягт уялдаатай бөгөөд төслийн хэрэгжилтийн хугацааны туршид агаар, гадаргын болон газар доорхи ус, хөрсний чанар, ургамал, амьтны аймагт гарч байгаа өөрчлөлтүүдийг тухай бүрт нь шинжилж, байгаль орчин болон хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөллийг тогтоох, түүний болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлж шаардлагатай арга хэмжээнүүдийг байгаль хамгаалах төлөвлөгөөнд нэмж тусгалаа.

Байгаль хамгаалах төлөвлөгөөний биелэлтийн үр дүнгийн тайланг тухайн оны 11 дүгээр сарын 01-ний дотор БОНХАЖЯаманд ирүүлэхээр тусгалаа.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
Газрын гадарга, хөрсөн бүрхэвч									
1	Гадаргын болон газрын доорх ус ахуйн шингэн хаягдлаар бохирдох	Био ариун цэврийн байгууламж ашиглан, ахуйн шингэн хаягдлыг ил задгай асгахгүй байх	Барилгын ажил хийгдэж буй талбай	-	-	-	-	-	Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага MNS 5924:2015
2	Хөрсний элэгдэл эвдрэл, бохирдол үүсэх	Барилга, газар шорооны ажил бүрэн дууссаны дараа нөлөөлөлд өртсөн нийт талбайг нөхөн сэргээж, хуучин төрх байдалд нь оруулах	Барилгын ажилд өртсөн талбайд	-	Төслийн барилгын ажлын зардалд хамаарна			-	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” MNS 5914:2008
3	машин механизмын хөдөлгөөнөөр агаарт тоосжилт үүсэх	Төслийн талбайд хурд сааруулагч хийх	Төслийн талбайд	ш	150	2	300	5 сард	Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016

Говь-Алтай аймгийн Жаргалант сумын Цахирын усалтын системийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4	Барилгын ажлын нөлөөгөөр байгалийн ургамлан нөмрөг устгах, доройтох	Барилгын материал, машин механизмуудыг аль холбох халцгай газарт байрлуулах, байгалийн ургамалтай газарт барилгын материал буулгах, машин механизмын зогсоол болгон ашиглахгүй байх			-	-	-		
5	Хүнд даацын машин механизмын дутуу шаталтат хөдөлгүүрээс хийн төлөвт бохирдуулагч ялгарч агаар бохирдуулах	Нийт машин механизмуудыг үзлэг оношилгоонд хамруулж, шаардлагатай бол хөдөлгүүрийг шинэчилж	Төслийн талбайд ажиллах нийт машин механизмыг		Үйл ажиллагааны зардалд суусан		Товлосон хугацаанд		MNS 5013:2009 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 5885:2008
Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
5	Ашиглалтын үед шүүрэлт үүсч, усны алдагдал ихсэх, ус хэрэглээ тооцоот хэрэглээнээс давах	Шүүрэлт үүсгэхгүй байхын тулд гол сувгийг бетоноор доторлох, гол сувгийн эргийн нуралтаас сэргийлэхийн тулд чулуун өрлөг хийх	Гадаргын ус		Төслийн барилгын ажлын зардалд хамаарна				

Говь-Алтай аймгийн Жаргалант сумын Цахирын усалтын системийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

6	Усалтын системийн ашиглалтын үед химийн бордоо, пестицидийн хэрэглээ, хадгалалтын нөхцөлөөс хамаарч хөрсний усаар дамжин гадаргын болон газрын доорх усыг бохирдуулж болзошгүй	Тариалангийн талбайгаас гол хүртэлх зайд (Цооног 1. 46°53'38.28" 96°10'45.97"E, Цооног 2. 46°52'43.66" 96°13'23.83"E) тус бүр шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглох	Төлөвлөсөн 2 цэгт 20 метрийн гүнтэй хоёр ширхэг мониторингийн цооногийг мэргэжлийн байгууллагаар гаргуулах	ш	5000.0	2	10000.0	Усны тухай хууль, 2012 он Усны чанар. Гүний усны бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх агууламж, MNS 6148:2010 Гүний усыг бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлагууд. MNS 3342:1982
7	Далангийн хаалтыг хаалттай байлгаснаас загас дамжин өнгөрөх боломжгүй болох	Суваг шуудуу, толгойн барилгын хаалт зэргийг загас өнгөрүүлэх боломжтой байхаар төлөвлөн байгуулах	Толгой барилга байгууламж		Төслийн барилгын ажлын зардалд хамаарна.		Барилгын ажлын үед	Усны барилга байгууламжийн зураг төсөл зохиох үндсэн журам
8	Усан орчинд амьдарч буй амьтдын амьдрах орчныг өөрчлөх,	Гол суваг, усан санд загас орвол амьдрах орчны хувьд тохиромжгүй тул толгойн барилгад загас орохоос сэргийлсэн тор тавьж гол суваг руу загас орохгүй дамжин өнгөрөх нөхцөлийг бүрдүүлэх	Толгой барилга байгууламж	-	Барилгын ажилын зардалд суусан		Барилгын ажлын үед	Усны барилга байгууламжийн зураг төсөл зохиох үндсэн журам

Говь-Алтай аймгийн Жаргалант сумын Цахирын услалтын системийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	Гадаргын усны урсац, горим өөрчлөгдөх	Барилгын ажлын үед голын байгалийн үндсэн гольдирол, урсцыг өөрчлөх үйл ажиллагаа явуулахгүй байх		-	Барилгын ажил эхлэхээс дуусах хүртэлх бүх цаг үед			Усны тухай хууль, БОНХАЖСайд, БХБСайдын 2015оны А230/127 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам
	Нийт						1030.0	

Говь-Алтай аймгийн Жаргалант сумын Цахирын услалтын системийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Барилгын ажлын үед эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, ойн зурвас байгуулах ажлуудын төлөвлөгөөг энэ хэсэгт тусгасан ба нийт 34.5 сая төгрөг зарцуулахаар төлөвлөв. “Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага” MNS5918:2008 стандартын дагуу 2023 оны хаврын тарилтаар зүлэгжүүлэлтийг эхлүүлнэ. Шугам хоолойн талбайг цэвэрлэх, тэгшлэх, хэлбэршүүлэх замаар нөхөн сэргээх болон биологийн нөхөн сэргээлтийн бэлтгэл ажлуудыг хангана.

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1.	Гадаргын усны ууршилтыг багасгах, хөрс хамгаалах, нөхөн сэргээх	Услалтын системийн талбайг тойруулан 10.1 га талбайд ойн зурвас байгуулах	Төслийн талбайг	ш	5000	3.0	15000.0	Хавар, намрын тариалалтын үеэр	Мод, сөөгний үр тарих. Ерөнхий шаардлага MNS 6253-2 : 2011
2.	Ойн зурвасыг хамгаалах	Ойн зурвасын ургалт хэвийн болж тогтворжих хүртэл малын хөлөөс хамгаалж хашаалах	Төслийн талбайг	метр	10000	1500	15000.0	6 дугаар сард	Мод, сөөгний суулгац арчлах MNS 6258-2:2011
3.	Биологийн нөхөн сэргээлт хийх нөхцөлийг бүрдүүлэх	Барилга, газар шорооны ажил дууссаны дараа эвдрэлд орсон талбайг хэлбэршүүлэх, тэгшлэх, үржил шимт хөрсөөр хучих, шаардлагатай тохиолдолд хөрс сайжруулалт хийх зэргээр ургамалжуулах урьдач нөхцөлийг бүрдүүлэх	Барилгын ажилд өртсөн талбай	-	-	-	4650	8 сард	MNS 5915:2008, MNS 5917:2008, MNS 5918:2008, Биологийн Нөхөн сэргээлт хийх журам
Нийт							34.650.0		

7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээн ий цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангаагүй эсвэл хэрэглээгүй, ХАБЭА-н дүрэм зөрчигдсөн үед болзошгүй осол аваарт өртөх	Барилгын талбай дээр ажиллах бүх ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж, хэрэглүүлж хэвшүүлэх	Төслийн талбайд ажиллах ажилчид					
2.	Ослын нөхцөл хүндрэх	Барилга, газар шорооны ажил явагдах талбайн орчимд анхааруулах тэмдэг тэмдэглэгээ, санамж байрлуулах, хязгаарлалтын бүс тогтоох	Төслийн талбай	2	100.0	200.0	5 сард	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он Барилгын тухай хууль, 2016 он
	Болзошгүй аюул ослын улмаас гал гарах	Галын аюулгүй байдлыг хангаж, гал унтраах анхан шатны болон суурин тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдийг байршуулах, галын хор цэнэгтэй эсэхийг байнга шалгаж, цэнэг нь дууссан бол цэнэглүүлж байх						Галын аюулгүй байдлын тухай хууль, 2015 он Хөдөлмөр хамгаалалын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS4244: 1994
		Ажилчдад аливаа болзошгүй аваар ослын үед анхны тусламж үзүүлэх сургалт зааварчилгааг өгч, анхны тусламжийн эм тариа, багаж хэрэгслийг бэлэн байлгах	Нийт ажилчид	Үйл ажиллагааны зардалд суусан			4 сараас	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он
	Нийт							

НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1		Орон нутагтайгаа хог хаягдлын гэрээ байгуулж ажиллах		удаа	-	1	-	4 дүгээр сард	Хог хаягдлын тухай хууль (2012)
2	Ахуйн	Дахин боловсруулах боломжтой хаягдлыг нягтаршуулах зориулалт бүхий “хаягдал пресслэгч машин” худалдан авч ангилан ялгасан хаягдлуудыг нягтаршуулан тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх		ш	-	1	5000.0	5 дугаар сард	Хог хаягдлын тухай хууль,
3		Барилгын ажил дуусахад талбай дээр ямар ч хог хаягдал үлдээхгүй цэвэрлэж явах	Барилгын ажлын дараа	-	Үйл ажиллагааны зардалд суусан		Барилгын ажил дуусны дараа	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344:2011	
4		Нийтийн их цэвэрлэгээ хийх		Удаа	Үйл ажиллагааны зардалд суусан			Хог хаягдлын тухай хууль (2012)	
5		Хог хаягдлыг хувиарын дагуу ачиж төвлөрсөн хогийн цэгт хаях	Төслийн талбай	удаа	50.0	10	500.0	14 хоногт 1 удаа	Хог хаягдлын тухай хууль (2012)

Говь-Алтай аймгийн Жаргалант сумын Цахирын услалтын системийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

6	Үйлдвэрийн	Үүссэн хаягдлыг дахин ашиглах боломж бололцоог судлах, ашиглаж болохуйц зуурсан шавар, бетон, модон болон төмөр эдлэхүүн зэрэг хаягдал, үлдэгдэл материалуудыг орон нутгийн иргэдэд өгөх			-	-	-	Барилгын ажлын үед	
7	Аюултай	Машин механизмын засвар үйлчилгээнээс гарсан аюултай хог хаягдлыг тусгай зориулалтын битүүмжлэлтэй саванд (цэг) хадгалж, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх			-	-	-		Хог хаягдлын тухай хууль, 2017 он Байгаль орчны сайдын 2003 оны 127 дугаар тушаал, Аюултай хаягдлын хадгалалт, устгалын бүртгэл хөтлөх, мэдээ гаргах заавар Аюултай хог хаягдлын хадгалалт ба устгалын бүртгэл
	Нийт						5.500		

ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	
Агаарын чанар								
1.	Хорт хий, бохирдуулагч бодисууд: Тоос /PM10, PM2.5/ CO2 502 ^02 Дуу чимээ хэмжих	Төслийн талбай, кемп	2цэгээс*2дээж* 2удаа	2	40.0	320.0		Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ, Техникийн ерөнхий шаардлага /MNS 5885:2008 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS4585:2016
Хөрсний чанар, хяналт								
2.	Хөрсний шинжилгээ /хими, физик шинэж чанар/	Төслийн талбай орчимоос	3цэгээс*2удаа* 2 дээж	2 удаа	30.0	360.0		Байгаль хамгаалал. Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтүүдийн нэр төрөл/ MNS 3985-1987/ Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008. Хөрс. Эрүүл ахуйн үзүүлэлтүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ MNS 3297:1991 Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам +360MNS2305 : 1995
3.	Хөрсний шинжилгээ / хүнд металл/	Кемп, төслийн талбай, машин механизмын зогсоолын орчмын талбайгаас	3цэгээс*2удаа *2 дээж	2 удаа	40.0	480.0		
3.	Нянгийн бохирдол:	Түр хогийн цэг, ажилчдын ариун цэврийн байгууламж орчимоос	2цэгээс*2удаа *2 дээж	2 удаа	40.0	320.0		

Говь-Алтай аймгийн Жаргалант сумын Цахирын усалтын системийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Усны чанар хяналт							
4.	Усны химийн ерөнхий шинжилгээ Усан дахь бохирдуулагч бодисуудын хэмжээ тодорхойлох	Завхан голоос	1цэгээс*2удаа* 2 дээж	Хавар, зун	50.0	200.0	Байгаль орчин. Хүний эрүүл мэндийн хамгаалалт. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл Ахуйн шаардлагууд болон чанарын хяналт MNS 900:2018
5.	Усны химийн ерөнхий шинжилгээ Усан дахь бохирдуулагч бодисуудын хэмжээ тодорхойлох (Хүнд металл-54)	Завхан голын уснаас	1цэгээс*2удаа* 2 дээж	Хавар, зун	50.0	200.0	
Нийт						1,880	

АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2023он				
			2022 он 12 сар	2023 он 01 сар	2023 он 02 сар		
	1	2	3	4	5	6	7
1.	БОМТ-ийн төлөвлөгөөг батлагдсан журмын дагуу боловсруулан эрх бүхий байгууллагаар баталуулах тайлагнах	1.000.0					
2.	Мониторингийн цэгийг байгуулах цооног өрөмдөх зөвшөөрөл Говь-Алтай аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газраас авах	200.0					
Нийт		1200.0					

11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1.	2023 оны БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг еic.mn сайдаар илгээж Говь-Алтай аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлнэ.	Цахимаар	2023 оны БОМТ-ийн биелэлтийн тайлан	2023 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө	100.0	Компаний захирал, Байгаль орчны ажилтан	
	Нийт				100,0		

12. ДҮГНЭЛТ

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа БОННУ ний тайланд тусгагдсан байгаль орчныг хамгаалах болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн боловсруулав. Байгаль орчинд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийн бууруулах, арилгах заавар зөвлөмж, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа, давтамж, хөрөнгө зардлыг тусгасан болно.

2023 оны сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээнд 10.300.000 Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн арга хэмжээнд 34.650.000 осол, эрсдлийн менежмент төлөвлөгөө, хог хаягдлын менежмент төлөвлөгөө 5.500.000 байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр 1.880.000, удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө 1.200.000, хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх үйл ажиллагаанд 100.000 “Алтайн үндэс констракшн” ХХК-ийн БОМТ үйл ажиллагаанд нийт 53,630,000 төгрөгийг хөрөнгө оруулалтыг зарцуулахаар төсөвлөсөн байна.

